

ДеФакто **НИЙТЛЭЛ**

# ЦААЗААР АВАХ ЯЛЫГ СЭРГЭЭХ ТУХАЙД

Манай нийгэм тогтворжоогүй, хувь хүн нь төлөвшөөгүй байгаа учраас цаазын ялыг халсан нь буруу алхам байсан хэмээн...

II НҮҮРТ

ДеФакто **ЯРИЛЦЛАГА**

Ш.БАТЦЭЦЭГ:

ӨНДӨР ТҮВШНИЙ УУЛЗАЛТУУД ЗОХИОН  
БАЙГУУЛАХААС ГАДНА ЭЛЧИН САЙДЫН  
ЯАМ "АМЬД" ҮЙЛ АЖИЛЛАГААГ

# БАРИМТЛАХ ХЭРЭГТЭЙ

IV НҮҮРТ

# The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

ЗОРИГЖУУЛНА


МЭДЭЛЖҮҮЛНЭ

Лхагва, 2018.01.03, №28

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХАРААТ БУС, БИЕ ДААСАН ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН

www.defacto.mn

# ЦААЗААР АВАХ ЯЛЫГ СЭРГЭЭХ ТУХАЙД





№ 412

Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**

Долоо хоног бүрийн нийтлэл,  
<http://jargaldefacto.com/category/23>

## ЦААЗААР АВАХ ЯЛЫГ СЭРГЭЭХ ТУХАЙД

**М**анай нийгэм тогтворжоогүй, хувь хүн нь төлөвшөөгүй байгаа учраас цаазын ялыг халсан нь буруу алхам байсан хэмээн Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2017.10.16-нд мэдэгдэв. Төдөлгүй Ерөнхийлөгч Хууль зүй, дотоод хэргийн яаманд цаазын ялыг сэргээх саналаа албан бичгээр хүргүүлэв. Энэ мэдэгдлээс хойш цаазааравах ялыг сэргээх, үгүй талаар нийгэм талцан, өнөөг хүртэл хүчтэй маргалдаж байна.

Цаазаар авах ялын тухай аль болох бодитой, судалгаа, үндэслэлтэй хэлэлцүүлэхээр ДеФакто Мэтгэлцээнийг бид 2017.12.28-нд VTV телевизээр зохион байгууллаа. Цаазаар авах ялыг сэргээхийг

дэмжин МУ-ын Ерөнхийлөгчийн Иргэний нийгэм, хүний эрхийн бодлогын зөвлөх, УИХ-ын гишүүн асан Г.Уянга, эсэргүүцэн Эмнести Интернэшнл Монгол байгууллагын удирдах зөвлөлийн дарга Б.Болорсайхан нар энэ мэтгэлцээнд оролцлоо.

НҮБ-ын Ерөнхий Ассемблейн “цаазаар авах ялыг төгсгөл болгох тухай” тогтоолыг 2007 онд 104 орон дэмжиж, 54 орон эсэргүүцэж, 29 орон түдгэлзсэн юм. МУ дэмжиж, Ерөнхийлөгч асан Ц.Элбэгдорж 2009 оны 1-р сард Их Хуралд хэнийг ч цаазаар авах зарлиг гаргахгүй гэдгээ мэдэгдсэн бөгөөд түүнээс хойш энэ ялыг хэрэгжүүлээгүй явж ирлээ.

## ЦААЗААР АВАХ ЯЛЫГ СЭРГЭЭХ НЬ ЗӨВ

Ерөнхийлөгч Х.Баттулгын зөвлөх Г.Уянга энэ ялыг халахдаа урьдчилан, иж бүрэн судалгаа, дүгнэлт хийгээгүй учир олон улсад тухайн үеийн Ерөнхийлөгчийн нэр хүндийг өргөсөн болохоос биш бодит амьдралд зохицоогүйг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн албан бичигтээ тодорхой дурдсаныг тэмдэглэв. Энэ ялыг яагаад сэргээх шаардлагатай тухай түүний үндэслэлийг тоймлон хэлбэл:

Нэг. Бага насны хүүхдийг хүчирхийлсэн, бэлгийн дарамтанд оруулсан, амь насыг нь хөнөөсөн гэмт хэргийн гаралт нэмэгдэх болсон нь нийгмийг цочроож байна. Хүний эрхийн үндэсний комисс 2015-2016 онд 2-7 насны 298 хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн тухай мэдээлсэн. Төр хүчирхийлүүлсэн бага насны хүүхдийн эрхийг хүчирхийлсэн этгээдийн эрхтэй зэрэгцүүлж үзэж болохгүй. Ер нь ямар эрэмбэтэй байх ёстой юм бэ? Цаашид ийм төрлийн гэмт хэрэг гарахгүй байхын тулд монголын төр шаардлагатай бүх арга хэмжээг авах хэрэгтэй. Юуны өмнө бага насны хүүхдийг бэлгийн замаар хүчирхийлсэн хэрэг нэг бүрийг олон нийтийн өмнө дэлгэж тавих ёстой.

Бид хүчирхийлсэн этгээдийн амьд явах эрхийн тухай ярьж байна. Гэтэл хүчирхийлүүлж амь насаа

алдсан хүний эрх хаана нь байх юм бэ?

Хоёр. Хууль гэдэг бол тухайн гэмт хэрэгтний үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон шийтгэл оногдуулахыг хэлдэг. Тэгж байж л нийгэмд шударга ёс тогтоно. Ямар ч шийтгэл, арга хэмжээ авлаа гэсэн хүчирхийлэлд өртсөн хохирогчийн хохирлыг бүрэн барагдуулах боломжгүй. Тэгсэн ч гэсэн ямар ч төрлийн гэмт хэрэгтэнд аль болох тохирсон ял, шийтгэл хүлээлгэх ёстой. Үүнд л аливаа хуулийн өөрийнх нь нийгмийн



ач холбогдол оршино.

Гурав. Эдгээр ноцтой гэмт хэргийн гаралт яагаад нэмэгдэх болсон, тэдгээрийг яаж таслан зогсоох талаар Ерөнхийлөгч Х.Баттулга холбогдох байгууллагуудтай уулзаж, байгаа мэдээлэл судалгааг нь авсан. Ингээд олон талын, зөрөөтэй байр суурийг харьцуулан дүгнээд цаазаар авах ялыг сэргээх шийдвэрийг гаргасан. Тэгээд ч МУ-ын Үндсэн

хуулийн 16-р зүйлийн 1-т “Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно” хэмээн заасан. Бас Үндсэн хуулийн 10-р зүйлийн 4-т “МУ Үндсэн хуульдаа харшилсан ОУ-ын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй” гэсэн заалт ч байгаа.

## ЦААЗААР АВАХ ЯЛЫГ СЭРГЭЭХ НЬ БУРУУ

Нэг.Судлаач Б.Болорсайхан гэмт хэрэг гарч буйн суурь шалтгаан нь иргэдийн эдийн засгийн баталгаа хангагдаагүй, ядуурал өсч байгаа явдал гэлээ. Үндсэн хуульд заасны дагуу төр нь иргэнийхээ өмнө хууль зүйн, эдийн засгийн болон бусад баталгааг нь хангах үүрэгтэй. Энэ үүргээ төр биелүүлэхгүй байна.

Хоёр. Монгол улс хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлоон бүтээх зорилготой гэж үндсэн хуулийн оршил хэсэгт заасан. Тэгэхийн тулд хүний эрх, эрх чөлөөг хангах, баталгаажуулах талаар хүн төрөлхтний бүтээсэн ололт амжилтыг дээдэлж, улс орондоо бүрэн дүүрэн хэрэгжүүлэх ёстой. Дэлхий дахинаа цаазаар авах ялыг халах хандлага сүүлийн дөчөөд жилд хүчтэй тогтлоо. Цаазаар авснаар тухайн улс оронд хүний амь насанд халдах эсвэл хүчингийн гэмт хэрэг буурч байгаа, эсэх талаар тодорхой судалгаа эдүгээ хаана ч хийгдээгүй байна.

Гурав. Гэмт хэрэг үйлдсэн л бол хийсэн үйлдлийнхээ төлөө хэн ч гэсэн хариуцлага хүлээх ёстой. Хууль хүн бүрт адил тэгш үйлчилдэг байх ёстой. Гэтэл манай шүүхийн тогтолцоо өнөөдөр тэгж чадахгүй,

алдаа, мадагтай шийдвэр их гаргаж байгаа учир цаазаар авах ял оновчтой биш. Цаазаар авах ялыг хүлээн зөвшөөрөхөөсөө өмнө төр өөрийн чиг үүргээ дорвитой биелүүлэх шаардлагатай байна.

Дөрөв. Хүний эрхийн үндэсний комисс цаазаар авах ялыг халах шаардлагатай байгааг удаа дараа мэдэгдэж байсан. Монгол улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх ёстой. Манай улс ямарваа нэгэн ОУ-ын гэрээнд нэгдэн орох, түүнийг соёрхон батлахаас өмнө тэдгээр баримт бичгүүдийн агуулгын биелэлтийг хангаж чадах уу, үндсэн хуулийн үзэл баримтлалтай зөрчилдөж байгаа эсэхийг төрийн холбогдох мэргэжлийн байгууллага нь хариуцаж судалдаг. Цаазын ялыг цуцлах тухай ОУ-ын гэрээг хүлээн зөвшөөрөхийн өмнө ч энэ ажил хийгдсэн. Тэгээд ч энэ бол МУ-д үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил мөрдөгдөж буй бас нэг эрх зүйн зохицуулалт гэлээ.

## ТӨГСГӨЛД НЬ

Ерөнхийлөгчийн Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн дээрх санал нь ямар нэг эцсийн шийдвэр биш. Цаазын ялыг сэргээхийн тулд Улсын Их Хурлаар баталж, хууль гаргах ёстой. Зөвхөн түүний дараа шинэ хууль хүчин төгөлдөр болно. Энэ асуудлыг хэрхэн шийдэх талаар юуны өмнө Засгийн Газар хэлэлцээд, Их Хуралд саналаа оруулах ёстой.

Гэхдээ энэ ялыг сэргээх эсэх тухайд иргэд бид ч сайн мэдээлэл, судалгаатай болж, хэлэлцэн ярилцаж чадваас төр засаг бодитой, ухаалаг шийдвэр гаргахад нь нөлөөлөх юм.

Энэ бол ардчиллын хамгийн энгийн, хамгийн хүчирхэг арга зам.

*Мэтгэлцээний бүрэн эхийг*

<https://www.youtube.com/watch?v=ocUnoqgBTKM>  
холбоосоор үзнэ үү.

2018.01.03



**Ш.БАТЦЭЦЭГ**

Монгол улсаас Индонези улсад сууж байсан элчин сайд

## ДеФакто **ЯРИЛЦЛАГА**

Монгол, англи, орос хэл дээрх ярицлага, <http://jargaldefacto.com/category/8>

# ӨНДӨР ТҮВШНИЙ УУЛЗАЛТУУД ЗОХИОН БАЙГУУЛАХААС ГАДНА ЭЛЧИН САЙДЫН ЯАМ “АМЬД” ҮЙЛ АЖИЛЛАГААГ **БАРИМТЛАХ ХЭРЭГТЭЙ**

*Шагдарын Батцэцэг нь 2010 онд Бизнесийн удирдлагын магистрын зэрэг хамгаалсан бөгөөд Боловсролын удирдлагын докторын зэргээ Энэтхэг улсад хамгаалжээ. 2009-2014 онд МУ-ын Ерөнхийлөгчийн зөвлөхөөр ажиллаж байсан. 2014 онд Монгол улсаас Индонези улсад суух элчин сайдаар томилогдохоос өмнө Дэлхийн банкны үндэсний зөвлөхөөр ажиллаж байсан.*

**Д.Ж:** Та Монгол улсаас Индонези улсад суух элчин сайдын ажлаа хүлээлгэж өгөөд ирснээсээ хойш юу хийж байна вэ?

**Ш.Б:** Би ирээд нэг сар болж байна. Монголын ардчиллыг дэмждэг хүнийхээ хувьд Ардчилсан нам дээр очиж, чадахаараа тусалж байна. Шинэ Ерөнхийлөгчөөс орон тооны зөвлөхөөр ажиллах ажлын санал авсан учраас хамгийн анхаарал татсан ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр боловсруулалт хийгээд явж байна.

**Д.Ж:** Ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн тал дээр анх таны оруулж ирж байсан Ротари хөдөлгөөн маш олон ажил, төслүүд хийсэн. Монгол улсаас Индонези улсад суусан анхны элчин сайд байсны хувьд Индонези болон бусад АСЕАН-ы орнууд монголд ямар ач холбогдолтой тухай яриач.

**Ш.Б:** Би АСЕАН-ы орнуудад суух анхны элчин сайд болсон ч гэсэн сүүлийнх нь биш байх, яагаад гэвэл Индонези улсад байгаа манай элчин сайдын яам татан буугдаагүй, түр хугацаагаар ГХЯ-аас санхүүжилт зогсоосон байгаа. Энэ нь хэдийгээр манай дипломат харилцаанд хар толбо үлдээж байгаа ч УИХ-ын бүрэн эрхээр баталгаажуулж байгаа учраас цаашдаа үйл ажиллагаагаа явуулах боломжтой. Дорой буурай амьдралтай Азийн 10 орон нэгдэхээрээ ямар хүчирхэг байж болохыг бид АСЕАН-ы жишээнээс харж болно. Индонези улс Зүүн Өмнөд Азид хамгийн их хүн амтай, хөгжлийн индексээрээ тэргүүлдэг орон бөгөөд 140 гаруй улсын элчин сайдын яам, 20 гаруй олон улсын байгууллагын төв оффис үйл ажиллагаагаа явуулдаг. 260 сая гаруй хүн амтай, 17.500 арлынхаа 300 гаруй арал дээр засаг захиргааны нэгж байгуулсан, газар нутгийнх нь үлдсэн хэсэг онгон байгалиараа байдаг улсад элчин сайдаар томилогдож очсоноосоо хойш АСЕАН-д монголын төлөөлөгчийн үүргийг давхар хариуцаж ирлээ. Өндөр хөгжилтэй орнууд АСЕАН-ы төлөөлөгчиддөө тусад нь элчин сайдын яам байгуулж ажиллуулдаг, энэ нь эдийн засаг, бодлогын ач холбогдолтой.

**Д.Ж:** АСЕАН-ы орнуудтай эдийн засгийн ямар харилцаа үүсгэх боломжтой вэ?

**Ш.Б:** АСЕАН-ы орнуудын эдийн засаг нь жил бүр илүү өсөлттэй байна. Татварын нэгдсэн систем, худалдааны нэгдсэн тариф, нэгдсэн тээврийн сүлжээтэй, маш хурдан, үр дүнтэй буюу холбоос сайтай систем рүү ороод эхлэхээр Европ, Америк, Африк тивүүдэд хүчтэй нөлөөлөөд эхэлж байна. Бид 1990 онд чөлөөт зах зээлд шилжсэнээс хойш яриа хэлэлцээрийн түнш болон хүсэлтээ илэрхийлсээр

ирсэн. Тодорхой хэмжээний статус, босгонд хүрсэн байх ёстой, гэтэл Засгийн газар маш хангалтгүй ажилласаар ирсэн. Индонезийн шинэ Ерөнхийлөгч G-20 улсын тоонд орсон байгаагаас G-5 буюу эдийн засгаараа 5-рт орох улс болгох зорилго тавьсан байгаа. Энэ хурдацтай хөгжилд бид хөл нийлүүлж чадахгүй бол ямар ч тивд харьяалагдаж чадахгүй, эдийн засгийн маш сул хөгжилтэй улс болох гээд байгаа юм.

**Д.Ж:** Монгол улс Индонези улстай дипломат харилцаа тогтоогоод хэдэн жил болж байна вэ?

**Ш.Б:** Бид элчин сайдын яамаа хаах үед 60 жилийн ойгоо тэмдэглээд дууслаа. 2012 онд Индонезийн Ерөнхийлөгч асан Сусило Бамбанг Юдоёно Монгол улсад айлчилж ирэхдээ Монгол улс, тэр тусмаа дипломат харилцаа ямар хурдацтай хөгжиж байгааг дурдан хэлээд элчин сайдын жуух бичиг гардуулж өгч байлаа. Тэр үед хэлсэн “тавтай морил” гэсэн үгний цаана “бидэнд бүх боломж нээлттэй байна” гэж хэлж байна гэж ойлгож байсан. 60 жил болсон ч гэсэн маш удаан хөгжилтэй, 3-4 жилдээ нэг өндөр түвшний айлчлал хийгээд болдог байсан харилцааг сайжруулах зүгээс өөрийн хийж чадах бүхнээ хийлээ.

**Д.Ж:** Ажиллах хугацаандаа юу хийсэн бэ?

**Ш.Б:** Амьд хөтлөлт, түүнийг явуулах элчин сайдын яамны ажилчдын санаачлага их чухал юм билээ. Бусад орнуудын элчин сайдууд дагалдах үйл ажиллагаа, улс орноо таниулах өдөрлөгүүдэд төсөв авдаг эсэхийг мэдэхгүй юм байна. Миний хувьд гурван жилийн турш ямар ч төсөвгүй ажиллах хэрэг гарсан учраас дипломат харилцааны дүрэм журмыг эвдэхгүйгээр юу хийж болох вэ гэдгийг судалж үзсэн. Эх орноо гэсэн сэтгэлтэй шинэ элчин сайд ирсэн байна, юугаар туслах вэ гэсэнд Монгол улсыг танилцуулахын тулд амьд харилцаатай, байнгын төв хэрэгтэй байна гээд Гэр соёлын төвийг байгуулсан. ГХЯ дээр ажлаа тайлагнаж байхад миний ажлын энэ хэсгийг хамгийн их сайшааж байсан, яагаад гэвэл элчин сайдын яаманд ажиллаж байгаа хүмүүс, тэдгээрийн гэр бүл гээд хийх ажилгүй суух явдал их байдаг тул тэрийг идэвхжүүлж өгснөөрөө онцлог болсон юм болов уу.

**Д.Ж:** Элчин сайдын яам хэдэн хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байсан бэ?

**Ш.Б:** Хоёр дипломат ажилтан, нэг жолооч, нэг техникийн ажилтны бүрэлдэхүүнтэй жижиг элчин сайдын яам тийм том зах зээлд ажиллаж байлаа. Бид их ажил санаачилж, хэрэгжүүлж байсан. Хэдийгээр ардчилсан нийгэмтэй

ч гэсэн төр нь их хүнд сурталтай учраас тэднээр ажлаа бүтээлгэхийн оронд тухайн улсын иргэд олноор цугларч хийдэг хобби юу байна гээд хартал гольф байсан. Газар түрээслээд хүмүүс уриад хийх боломжгүй байсан учраас гольфийн талбай дээр очиж танилцуулга, илтгэл тавьж байлаа. Нэг их сургууль дээр лекц уншсан Ерөнхийлөгчтэй холбоо тогтооход томоохон арлуудад маш том гольфын талбайтай хүн байж таараад бидний Монгол гольфын өдрийг зохион байгуулахыг зөвшөөрсөн. Жакартагаас 3 цагийн зайтай, Энэтхэгийн далайн эрэг дээр 100 га газар өгөөд 4 гэр, морины жүчээ, нум сум харвах талбай зэргийг байгуулсан байгааг одоо Индонезийн аялал жуулчлалын компани, элчин сайдын яаманд ажиллаж байсан ажилтныг нэг жилийн гэрээтэй зөвлөхөөр аваад хариуцаж авч явж байгаа.

**Д.Ж:** Тэнд танин мэдэхүйн газар нээснээр монгол руу ирэх жуулчдын тоо ихсэх үү?

**Ш.Б:** Мэдээж хэрэг бидний байгуулсан газрыг хараад яг нутагт нь очоод үзэх юмсан гэсэн сэтгэл төрөөд монгол руу аялалаар ирж байгаа хүмүүс байна. Аялал жуулчлалын мэдээллийн төв дутагдалтай байгааг олж хараад мөн нээсэн бөгөөд намайг ажиллаж байх хугацаанд 600 гаруй хүн ирсэн.

**Д.Ж:** Хоёр талдаа визгүй болсон уу?

**Ш.Б:** Үгүй. Гэхдээ би ажиллаж байх хугацаандаа монголчуудыг Индонезид визгүй зорчих эрхийг авч чадсан. Харин индонезиуд ямар ч ажлаар ирсэн виз авна.

**Д.Ж:** Хувь хүмүүс арал худалдаж авдаг шиг Монгол улс Индонези улсын нэг арлыг нь худалдаж авах боломжтой юу?

**Ш.Б:** Монголчуудад байхгүй байх. Гэр соёлын төвийг байгуулсан, хот төлөвлөлтийн компанитай Драманогэхэрхэм Жабибайка гэх жижиг арлыг худалдаж аваад үйлдвэрлэлийн хот бий болгосон байгаа юм. Дотоодын бизнесүүд нь арал худалдаж авч болох ч гэсэн байнга хөрөнгө оруулалт хайж явдаг юм билээ. Ялангуяа Драманог моголоос хөрөнгө оруулалт авах их сонирхолтой байна лээ. Дотоодын эдийн засаг асуудалтай байгаа учраас би сайн дуугарч чадахгүй байна. Тэрнээс биш монголчууд Индонезитой хамтарч арал худалдаж аваад хөгжүүлэх боломжтой.

**Д.Ж:** Хувь хүн Индонезийн бизнестэй хамтарч онгоцоор хүмүүс аралд амраадаг бизнес ч хийж болох юм байна.

**Ш.Б:** Тийм, маш боломжтой. Хоосон газрыг ухаалаг бизнесүүд сайтар ашиглаж, амьд болгож чаддаг. Гэр соёлын төв маань далайн эрэг дээр байх бөгөөд одоо 30-40 Чингисийн онгоц хийгээд “Чингисийн цэргүүд дайлаар мордож байна” гэсэн мессежийг илэрхийлэхийг зорьсон байна лээ. Далай дор байх галт уул болон далайн эргийн хооронд Чингисийн цэргүүдийн аялал гэх усан аялал, мөн Чингис хаан зочид буудал гэх томоохон төслүүд бий болсон байна лээ.

**Д.Ж:** Дарга нар уулзаж дээд түвшний асуудлуудаа ярилцах чухал ч гэсэн иргэд, бизнесийн харилцаа байж гэмээн оршин тогтноно. Та үүнийг доод талаас нь хөгжүүлээд эхэлчихэж.

Монгол улсын гадаад харилцааг яаж сайжруулмаар байна вэ?

**Ш.Б:** Өндөр түвшний уулзалтууд зохион байгуулахаас гадна элчин сайдын яам “амьд” үйл ажиллагааг баримтлах хэрэгтэй гэж бодож байна. Энэ нь хоёр орны иргэд бие биетэйгээ танилцах хамгийн том гүүр юм. Мөн төсөв, хөрөнгө байхгүй гэж суухынхаа оронд хүмүүс хаана уулзаж байна, хэнтэй уулзах уу гэж явах нь тухайн элчин сайдын санаачлага юм. Олон ажилтантай элчин сайдын яамд хүмүүсийнхээ чадлыг ашиглах хэрэгтэй санагдсан. Надад ихэвчлэн ажилчдын гэр бүл, уул уурхайн инженерүүдийн гэр бүл гээд 50 гаруй хүн л байсан боловч маш идэвхтэй ажиллаж чадсан.

**Д.Ж:** Улсынхаа бизнесийн, хүмүүсийн, соёлын харилцааг сайжруулсан, улс орноо танилцуулсан гэдгээр нь ажлыг нь дүгнэхгүй бол хэдэн сайд уулзуулснаар дүгнэх нь учир дутагдалтай.

**Ш.Б:** Одоо хүртэл зарим элчин сайдууд тэр сайдыг уулзуулмаар байна, айлчлал хийлгэмээр байна гэдэг. Миний хувьд хоёр талын иргэдийг яаж уулзуулах, авчрах тал дээр ажиллах хэрэгтэй гэж боддог. Гэхдээ замбараагүй нааш, цааш явуулахгүй байх үүднээс аялалын үйлчилгээ үзүүлдэг бизнес ч бас хөгжүүлж болох юм.

**Д.Ж:** Манай аялал жуулчлалын компаниуд бүх газар дээр ажилладаг байхаасаа илүү төрөлжиж ажиллавал илүү үр дүнтэй байх юм болов уу.

**Ш.Б:** Халуун орны хүмүүс ирж байгаа, хүйтэн орны хүмүүс ирж байгаа, тэр бүрт тусгай үйлчилгээ үзүүлдэг баймаар байна. Тэр дундаа тодорхой хэмжээний өрсөлдөөнтэй байвал бүр сайн.

**Д.Ж:** Энэ бүгдийг хэрэгжүүлэхийн тулд мөн хэн дуртай нь нисдэг нээлттэй агаарын бодлоготой болмоор байна. Байгаа онгоцны нислэг нь хүрэлцээгүй байгаа шүү дээ.

**Ш.Б:** “Air Asia” Ази даяар монополи болж чадсан байна. Тэдэнтэй холбоо тогтоочих юм бол илүү нээлттэй болж чадна.

**Д.Ж:** Жижиг орны гадаад бодлого нь нээлттэй, том, сонин, өвөрмөц, иргэдтэйгээ харилцаатай байх ёстой. Таныг цахим орчин болон бусад баримтууд бүх зүйлс дээр хамгийн нээлттэй ажиллаж чадсан элчин сайд гэж бодож байна. Хүний санаачлага мөнгөнөөс чухал байдгийг та харуулж чадлаа. Таны хийж ирсэн ажлыг би харсан, талархаж байна.

**Ш.Б:** Тантай ярилцахад таатай байлаа. Баярлалаа.

2017. 11. 14

**Дефакто ярилцлагын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв.**

Ярилцлагын бүрэн эхийг <http://jargaldefacto.com/article/sh-battsetseg-battsetseg-shagdar> холбоосоор үзнэ үү.

Татгалзахын аргагүй САНАЛ


FORD EXPLORER | JAGUAR F-PACE | RANGE ROVER

ШАТАХУУНЫ ЭРХ | ӨВЛИЙН ДУГУЙ

АЯЛАЛЫН ЭРХ | СЕРВИС ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРХ

Холбоо барих: 99118301, 99106507, 99118375  
www.waa.mn

WAGNER ASIA AUTOMOTIVE LLC



## JARGAL DEFACTO ГАР УТАСНЫ АППЛИКЭЙШН



**NEW NISSAN PATROL**

☎ 9911-0014, 9911-5140, 9910-0167

**ЛИЗИНГИЙН НӨХЦӨЛ:**

Урьдчилгаа **0%**

Хүү **1.4%**

Хугацаа **84** сар

**УРАМШУУЛАЛ:**

  
Хамгаалалтын хуулга

  
Самбаг орсонхын эрх

  
4ц Олгийн дугуй

  
Салжны шиний хамгаалалт

**ҮНЭ: ₮214.0 сая**

Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол төлбөргүй хүлээн авахыг хүсвэл  
[www.jargaldefacto.com](http://www.jargaldefacto.com) болон [www.defacto.mn](http://www.defacto.mn) вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ.

### РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Дамбадаржаагийн Жаргалсайхан  
 Дангаасүрэнгийн Энхбат

### ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Ерөнхий редактор: Ганбаатарын Жавзмаа  
 Баг: Батхүүгийн Амар  
 Отгонсүрэнгийн Билгүүн  
 Өсөхбаярын Биндэръяа  
 Адъяагийн Тунгалаг

### ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com  
 ☎ +976 94109342  
 🌐 www.defacto.mn